



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/821

Улаанбаатар хот

“Урлагийн хот-Улаанбаатар” төслийг  
хэрэгжүүлэх зарим арга  
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.3.6, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.“Урлагийн хот-Улаанбаатар” төслийн хүрээнд шалгарсан “Нууцын эрэлд” жүжгийг 2018 оны 10 дугаар сарын 28-наас 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад үнэ төлбөргүй үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Соёл, урлагийн газар /Ж.Дамдинцэрэн/, Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/-т тус тус даалгасугай.

2.Уг арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах, энэ захирамжийн хавсралтаар баталсан 57.100.000 /тавин долоон сая нэг зуун мянган/ төгрөгийг нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан “Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардал”-аас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаад, уг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

  
С.БАТБОЛД

111020703057

Нийслэлийн Засаг даргын 2018 оны  
 09 дугаар сарын 05-ны өдрийн  
 Ахуйн захирамжийн хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН  
 БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Хянасан
"Нууцын эрэлд" хүүхдийн зохиолын жүжгийн төсөв						
1.	Зохиолчийн урамшуулал	хүн	1	3.000.000	3 000 000	2 500 000
2.	Найруулагчийн ажлын хөлс	хүн	1	2.500.000	2 500 000	2 000 000
3.	Туслах найруулагчийн ажлын хөлс	хүн	1	1.000.000	1 000 000	1 000 000
4.	Хөгжмийн зохиолчийн ажлын хөлс	хүн	1	2.000.000	2 000 000	2 000 000
5.	Хөгжмийн цомнол зохиогчийн ажлын хөлс	хүн	1	1.000.000	1 000 000	1 000 000
6.	Зураачийн ажлын хөлс	хүн	4	800.000	3.200.000	3 200 000
7.	Бүжиг дэглээч найруулагчийн ажлын хөлс	хүн	1	1.500.000	1 500 000	1 000 000
8.	Гол дүрийн уран бүтээлчдийн урамшуулал /30 хоног бэлтгэл, 30 хоног үзэгчдэд хүргэх тоглолт, 60 удаагийн үнэгүй тоглолт /	хүн	6	800.000	4 800 000	4 800 000
9.	Туслах дүрийн уран бүтээлчдийн урамшуулал /30 хоног бэлтгэл, 30 хоног үзэгчдэд хүргэх тоглолт, 60 удаагийн үнэгүй тоглолт /	хүн	10	600.000	6 000 000	4 000 000
10.	Бүжигчдийн ажлын хөлс	хүн	10	600.000	6 000 000	5 000 000
11.	Тайз, жижиг хэрэглэл, туслах материал, чимэглэл түрээслэх зардал /45 хоног/	үзэгдэл	3	4.600.000	13.800.000	11 400 000
12.	Жүжгийн хөгжмийн найруулга хийлгэх зардал /дуу, бүжиг, шум/	үзэгдэл	3		2 750 000	2 750 000
13.	Жүжигт ашиглах дуу, хоолойн бичлэг хийх, мастер хийх студийн зардал /60 минут/	үзэгдэл	3		2 300 000	2 300 000
14.	Телевизийн контент болгон бичүүлж, нэвтрүүлэх зардал		1	2.000.000	2 000 000	1 250 000
15.	Сурталчилгааны шторк хийх		1	1.000.000	1 000 000	1 000 000
16.	Жүжигт зориулсан дуу бүтээх зардал		1	1.500.000	1 500 000	1 000 000
17.	Жүжигт зориулсан дууны клип хийлгэх зардал		1	2.000.000	2 000 000	2 000 000
18.	Сурталчилгааны зурагт хуудас хийлгэх /А3/	ш	1000	2.000	2.000.000	1 000 000
19.	Нийгмийн сүлжээ, социал маркетинг, идэвхжүүлэлт хийлгэх зардал				1 000 000	
				ДҮН	59 350 000	49 200 000

Жүжгийн нээлт зохион байгуулахад шаардагдах зардал						
20.	Нээлтийн үйл ажиллагааны угтах танхимд байрлах хөөсөнцөр хэвлэл хийлгэх зардал	м2	20	30.000	600.000	600.000
21.	Урилга хэвлүүлэх	ш	150	2.000	300.000	300.000
22.	Хулдаасан хэвлэл хэвлүүлэх	м2	20	12.000	240.000	240.000
23.	Жүжгийн нэрийг биет үсгээр хийлгэх	үсэг	11	60.000	660.000	660.000
24.	Стэнд хэвлүүлэх	ш	4	45.000	180.000	-
ДҮН					1.980.000	1.800.000
Нийслэлийн 9 дүүргийн сурагчдад үзүүлэх тоглолтыг зохион байгуулахад шаардагдах зардал						
25.	Уран бүтээлчдийг зөөх автобус түрээсийн зардал	өдөр	14	200.000	2.800.000	2.100.000
26.	Уран бүтээлчдийг зөөх автобусны түлшний зардал	л	300	1950	585.000	-
27.	Тайз, хувцас, жижиг эд хэрэглэл зөөх автомашины түрээсийн зардал	өдөр	14	150.000	2.100.000	1.400.000
28.	Тайз, хувцас, жижиг эд хэрэглэл зөөх автомашины түрээсийн зардал	л	300	1950	585.000	-
29.	Нэмэлтээр тайз дэглэх туслах ажилтны урамшуулал	хүн хоног	4/14	400.000	1.600.000	1.600.000
30.	Гэрэл, дууны техникчийн урамшуулал	хүн хоног	2/14	500.000	1.000.000	1.000.000
ДҮН					8.670.000	6.100.000
НИЙТ					70.000.000	57.100.000